



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 11 сарын 27 өдөр

Дугаар 190

Улаанбаатар хот

“Цагаан алт” хөдөлгөөний хүрээнд
хэрэгжүүлэх зарим арга
хэмжээний тухай

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 63 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор
Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1-д заасныг үндэслэн
Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.“Цагаан алт” хөдөлгөөний хүрээнд малын гаралтай түүхий эд боловсруулах
үйлдвэрлэлийг дэмжих хөнгөлөлттэй зээлийг арилжааны банкны эх үүсвэрээр
санхүүжүүлэх арга хэмжээг зохион байгуулан ажиллахыг Монголбанкны Ерөнхийлөгч
Б.Лхагвасүрэнд зөвлөсүгэй.

2.Засгийн газраас хариуцан төлөх энэ тогтоолын 1-д заасан зээлийн хүүгийн
дэмжлэгийг түүхий эдийн боловсруулалтын үе шатыг харгалзан Монголбанкны бодлогын
хүүтэй уялдуулан тооцож, тухайн жилийн батлагдсан төсвийн хүрээнд зохицуулалт хийх
замаар хэрэгжүүлэн ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаярт
даалгасугай.

3.“Цагаан алт” хөдөлгөөнийг орон нутагт сурталчлан таниулах, идэвхжүүлэх арга
хэмжээ авч ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нар, Бүсчилсэн хөгжлийн
удирдлага (бүсийн зөвлөл)-д тус тус үүрэг болгосугай.

4.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт гадаадын зээл, тусlamжийн
хөрөнгөөр хэрэгжиж байгаа төслийдийн санхүүжилтийг “Цагаан алт” хөдөлгөөнийг
хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгасан төсөл, арга хэмжээтэй уялдуулан зохион байгуулж
ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаярт даалгасугай.



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН
ҮЙЛДВЭРИЙН САЙД

ИДАА1234 9823100304 5458449

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

Ж.ЭНХБАЯР